



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/066НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.25 № 2/65
танай _____-ны № _____-т

МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.УЛААНХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 8.9.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй хугацаа хоцроосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөөгүй 2,357.7 мянган төгрөгийн зардал санхүүжүүлсэн,
- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн, 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгоогүй атал, тайлант оны төсөвт батлагдаагүй унаа, хоолны мөнгө олгосон зэрэг зөрчлүүд байна

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулалд 22.8 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 122.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Тайлант онд сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 419.4 сая төгрөгийн хандивын орлого бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ойн хандив, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүйгээр 489.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 137.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 9 зорилт 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>115,262,575.70</u>	<u>146,643,858.70</u>
33	АВЛАГА	25,364,590.70	40,931,543.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	47,610.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,093,730.50	35,639,073.50
335	Бусад авлага	5,270,860.20	5,244,860.20
3351	Байгууллагаас авах авлага	-	24,000
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,270,860.20	5,220,860.20
34	УРЬДЧИЛГАА	20,500,000	20,500,000
34600	Урьдчилж гарсан зардал	20,500,000	20,500,000
35	БАРАА МАТЕРИАЛ	69,397,985	85,212,315
354	Хангамжийн материал	34,495,985	49,810,315
35420	Аж ахуйн материал	34,495,985	49,810,315
35600	Мал амьтад	34,902,000	35,402,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,593,134,050.34</u>	<u>2,051,650,793.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,593,134,050.34	2,051,650,793.82
392	Биет хөрөнгө	1,552,244,050.34	2,011,060,793.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,376,638,035.46	1,819,451,848.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(379,108,861.08)	(483,619,256.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,380,950	159,380,950
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,034,951.04)	(86,894,484.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,426,015	322,177,585.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(156,907,829.08)	(171,684,487.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,836,308	177,081,308
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,600,474.44)	(74,842,340.92)
39209	Зам, гүүрийн байгууламж	432,103,735	432,103,735
39210	Хуримтлагдсан элэгдэл	(63,488,877.48)	(85,094,064.36)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	3,000,000.00
393	Биет бус хөрөнгө	40,890,000	40,590,000
39301	Программ хангамж	3,255,590	3,255,590
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,655,590)	(2,955,590)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,290,000	40,290,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,708,396,626.04</u>	<u>2,198,294,652.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>820,156.01</u>	<u>1,887,380</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	820,156.01	1,887,380
413	Өглөг	820,156.01	1,887,380
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	820,156.01	1,887,380
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,707,576,470.03</u>	<u>2,196,407,272.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,707,576,470.03	2,196,407,272.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	561,660,058	561,660,058
51101	Өмч: - төрийн	561,660,058	561,660,058
512	Хуримтлагдсан үр дүн	774,255,572.59	1,263,086,375.08
51210	Өмнөх үеийн үр дүн		774,255,572.59

51220	Тайлант үеийн үр дүн	774,255,572.59	488,830,802.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	371,660,839.44	371,660,839.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,708,396,626.04	2,198,294,652.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,099,819,423	2,469,186,899.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	254,545,921	942,244,864.80
120	Нийтлэг татварын бус орлого	254,545,921	522,826,364.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	254,545,921	522,826,364.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	652,000	1,259,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	253,193,921	521,566,864.80
122	Тусламжийн орлого	-	419,418,500
122001	Хандив тусламж /дотоод/	-	419,418,500
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	845,273,502	1,526,942,035
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	282,329,702	631,496,635
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	282,329,702	631,496,635
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,943,800	895,445,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,943,800	895,445,400
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	903,701,529.75	1,929,683,097.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	903,701,529.75	1,929,683,097.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	900,109,211.49	1,903,456,583.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,089,547.93	667,429,349.39
210101	Үндсэн цалин	399,407,397.93	349,701,081.38
210102	Нэмэгдэл	-	232,705,849.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,215,973.75
210104	Урамшуулал	-	40,187,134.50
210105	Гэрээт ажлын хөлс	682,150	27,619,310.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,839,736.06	82,899,002.60
210201	Тэтгэврийн даатгал	46,735,377.06	54,672,002.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,104,359	8,599,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,171,800
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,436,300
210205	Эрүүл мэндийн даатгал	-	13,019,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,907,104	52,173,372
210301	Гэрэл, цахилгаан	3,878,807.74	5,009,811.51
210302	Түлш, халаалт	32,643,256.04	39,488,900.00
210303	Цэвэр, бохир ус	7,385,040	7,674,660
2104	Хангамж, бараа материалын зардал	28,396,601	54,705,085

210401	Бичиг хэрэг	2,646,420	3,748,205
210402	Тээвэр, шатахуун	17,598,040	26,265,180
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,425,000	2,225,950
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,727,141	22,465,750
2105	Нормативт зардал	446,000	198,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	446,000	198,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,829,200	2,480,500
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	220,600	156,000
210604	Урсгал засвар	2,608,600	2,324,500
2107	Томилолт, зочны зардал	5,501,100	7,235,000
210702	Дотоод албан томилолт	5,501,100	7,235,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,123,339	7,200,070
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,179,525	5,946,650
210803	Даатгалын үйлчилгээ	145,000	346,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,860	200,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	605,080	400,000
210807	Газрын төлбөр	115,874	307,420
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	363,976,583.72	1,029,136,205.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	217,867,543.05	862,145,065
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000	583,500
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,589,040.67	166,407,640.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,592,318.26	26,226,513.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,745,000.00	24,527,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,782,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	1,745,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,847,318.26	1,699,513.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,847,318.26	1,699,513.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	196,117,893.25	539,503,802.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	70,000.04	50,673,000
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	70,000.04	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	50,673,000
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(70,000.04)	(50,673,000)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	196,047,893.21	488,830,802.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	853,854,220	1,972,713,765.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,352,000	425,678,000
120	Нийтлэг татварын бус орлого	1,352,000	6,259,500
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,352,000	1,259,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	652,000	1,259,500

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000	-
120009	Бусад орлого	-	5,000,000
122	Тусламжийн орлого	-	419,418,500
122001	Хандив тусламж /дотоод/	-	419,418,500
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	852,502,220	1,547,035,765.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	289,558,420	651,590,365.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	289,558,420	651,590,365.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,943,800	895,445,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,943,800	895,445,400
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	853,854,220.00	1,972,713,765.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,854,220.00	1,972,713,765.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	830,168,171.24	1,910,848,178.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	397,608,000	661,212,020.80
210101	Үндсэн цалин	236,952,772.07	343,483,752.79
210102	Нэмэгдэл	101,013,134.56	232,705,849.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,268,999.40	17,215,973.75
210104	Урамшуулал	29,946,896.94	40,187,134.50
210105	Гэрээт ажлын хөлс	25,426,197.03	27,619,310.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,164,495	86,255,579.20
210201	Тэтгэврийн даатгал	32,844,300	58,028,579.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,967,300	8,599,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,624,695	5,171,800
210204	Ажилгүйдлийн даатгал	780,600	1,436,300
210205	Эрүүл мэндийн даатгал	7,947,600	13,019,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,288,426.74	52,845,900
210301	Гэрэл, цахилгаан	3,878,807.74	6,570,140
210302	Түлш, халаалт	27,475,374	38,047,800
210303	Цэвэр, бохир ус	6,934,245	8,227,960
2104	Хангамж, бараа материалын зардал	17,053,500	19,561,206.51
210401	Бичиг хэрэг	2,237,400.00	2,764,400
210402	Тээвэр, шатахуун	12,339,200.00	14,423,500
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,476,900.00	2,373,306.51
2105	Нормативт зардал	502,500	553,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502,500	553,700
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,737,300	2,773,700
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280,600	317,000
210604	Урсгал засвар	2,456,700	2,456,700
2107	Томилолт, зочны зардал	5,501,100	7,235,000
210702	Дотоод албан томилолт	5,501,100	7,235,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,265,760	17,830,530
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,104,526	16,051,110
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	145,000	346,000

210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,860	225,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	34,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,500	867,000
210807	Газрын төлбөр	115,874	307,420
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,047,089.50	1,062,580,542
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	304,347,089.50	1,061,096,542
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000	1,484,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,686,048.76	61,865,586.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,745,000	24,527,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,782,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000	1,745,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,847,318.26	1,699,513.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,847,318.26	1,699,513.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,093,730.50	35,639,073.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,093,730.50	35,639,073.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058	371,660,839.44	774,255,572.59	1,707,576,470.03
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058	371,660,839.44	774,255,572.59	1,707,576,470.03
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	561,660,058	371,660,839.44	774,255,572.59	1,707,576,470.03
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	488,830,802.49	488,830,802.49
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058	371,660,839.44	1,263,086,375.08	2,196,407,272.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	896,050,400	895,005,386.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,050,400	895,005,386.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,523,400	870,478,386.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,415,200	661,212,020.80
210101	Үндсэн цалин	363,468,700	343,483,752.79
210102	Нэмэгдэл	252,254,800	232,705,849.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,215,973.75

210104	Урамшуулал	17,011,700	40,187,134.50
210105	Гэрээт ажлын хөлс	31,680,000	27,619,310.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,052,400	86,255,579.20
210201	Тэтгэврийн даатгал	56,475,900	58,028,579.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,644,200	8,599,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,315,200	5,171,800
210204	Ажилгүйдлийн даатгал	1,328,800	1,436,300
210205	Эрүүл мэндийн даатгал	13,288,300	13,019,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,727,600	52,845,900
210301	Гэрэл, цахилгаан	6,451,800	6,570,140
210302	Түлш, халаалт	38,047,800	38,047,800
210303	Цэвэр, бохир ус	8,228,000	8,227,960
2104	Хангамж, бараа материалын зардал	20,531,100	19,561,206.51
210401	Бичиг хэрэг	2,754,400	2,764,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,423,500	14,423,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,353,200	2,373,306.51
2105	Нормативт зардал	553,700	553,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700	553,700
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,773,700	2,773,700
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000	317,000
210604	Урсгал засвар	2,456,700	2,456,700
2107	Томилолт, зочны зардал	7,235,000	7,235,000
210702	Дотоод албан томилолт	7,235,000	7,235,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,947,300	16,753,880
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,092,800	14,974,460
210803	Даатгалын үйлчилгээ	346,000	346,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000	225,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,000	34,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	867,000	867,000
210807	Газрын төлбөр	307,500	307,420
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,287,400	23,287,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,287,400	21,803,400
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,484,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,527,000	24,527,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,527,000	24,527,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,782,000	22,782,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000	1,745,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	896,050,400	895,005,386.51
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	895,445,400	893,745,886.51
132001	Орон нутгийн төсвөөс	895,445,400	893,745,886.51
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000	1,259,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	1,259,500
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	27
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	11	10
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	27

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 362,011.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 358,463.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 60,960.5 мянган төгрөгийн бараа материалыг хөрөнгийг худалдан авснаар бүртгэсэн,
- Авлага 147,178.3 мянган төгрөгөөр илүү,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 5,000.0 мянган төгрөгөөр илүү,
- Үндсэн хөрөнгийн тайлан оны хуримтлагдсан элэгдлийг 859.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Үнэ төлбөргүйгээр ирсэн 14,699.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг илүү бүртгэсэн
- Тайлант үеийн үр дүнг 129,765.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 3,548.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага, санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй хугацаа хоцроосон тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,548.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 1,190.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,357.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Албан хаагчдын цалингийн шатлалыг зөрүүтэй тооцон 1,190.3 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"; Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн, 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгоогүй, тайлант оны төсөвт батлагдаагүй унаа, хоолны мөнгөнд 12,048.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

16.5.4д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох 2019 оны 5 дугаар хавсралтын 2.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд журамд заасны дагуу үр дүнгийн урамшууллыг тооцон олгох, унаа хоолны мөнгө олгохгүй байх

5.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын 2024 оны жилийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх

5.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс багуудад 2,357.7 мянган төгрөгөөр гарын бэлэг худалдан авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

